



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2020 оны 05 сарын 26 өдөр

Дугаар А/211

Арвайхээр


Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны “Зорилтот жил болгон зарлах тухай” 12/04 дүгээр тогтоол, аймгийн Засаг даргын 2020 оны “Зорилтот жилийн төлөвлөгөө батлах тухай” А/102 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.“Өвөрхангайд үйлдвэрлэв” зорилтот жилийн хүрээнд зохион байгуулсан аймгийн брэнд бүтээгдэхүүний лого бүтээх уралдааны шагналд 2,000,000 (хоёр сая), зорилтот жилийн хулдаасан самбар хэвлэхэд 944,460 (есөн зуун дөчин дөрвөн мянга дөрвөн зуун жар) төгрөгийг тус тус зарцуулсугай.

2.Дээрх 2,944,460 (хоёр сая есөн зуун дөчин дөрвөн мянга дөрвөн зуун жар) төгрөгийг орон нутгийн төсөвт батлагдсан зорилтот жилийн ажлын зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газар (Ц.Ганболд)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Г.ГАНБОЛД

011100483